

ЦЭРГИЙН САХИЛГЫН МӨН ЧАНАР, НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Төр засгаас нийгмийн дэг журам, сахилга, харицлагыг бэхжүүлэх талаар хууль эрх зүйн тулгуур баримт бичгүүдийг боловсруулж гаргав.

Нийгмийн сахилга, дэг журам гэдэг бол өргөн ойлголт, үүнийг онолын талаас авч үзвэл төрийн хууль, тогтоомжийг заавал биелүүлэх сахилга, үндэсний шилдэг өв уламжлалтай хослуулан сахих явдал юм.

Цэргийн нийтлэг дүрмүүдэд: “Монгол Улсын хууль, тогтоомж, цэргийн дүрэм, бусад хууль эрх зүйн болон ёс зүйн хэм хэмжээ захирагч (дарга)-ийн тушаалаар тогтоосон дэг журмыг цэргийн бүх албан хаагч чанд сахин биелүүлэхийг цэргийн сахилга гэнэ” гэж тодорхойлжээ. Мөн цэргийн албан хаагч бүрийн биелүүлэх үүрэг, сахилгын хангагдах нөхцлүүдийг тодорхойлж, цэргийн албан хаагчдын хүлээх хариуцлагыг хуульчлан баталгаажуулсан байдаг. Дотоод албаны дүрэмд захирагч (дарга) нарын нийтлэг болон албан тушаалын үүргийг төрөлжүүлж тусгасан.

Цэргийн сахилга нь цэргийн байгууллагын өндөр зохион байгуулалт, албаа гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор төрийн хууль, цэргийн дүрмийг сахиулах, цэргийн албан хаагчдын хоорондын харилцаа нийгмийн холбоог зохицуулахад зориулагдсан маш нарийн олон талт үзэгдэл юм.

Улсын хил хамгаалах албаны нийгмийн зориулалт, шинж чанар, агуулга, дэлхийчлэлийн нөхцөл дэх өнөөгийн байдал, хатуу чанд сахилга, алба, үйл ажиллагааны бүх хүрээнд хууль, дүрмийг хэлбэрэлтгүй сахихыг бие бүрэлдэхүүнээс шаардаж байна.

Орчин үеийн нийгмийн доторх зөрчил, тэмцлийн шинж чанар, хоорондын уялдаа холбоос нарийсч өөрчлөгдсөн.

Дэлхийчлэлийн нөлөөгөөр дэлхий дахины цэрэг, улс төрийн байдал эрс өөрчлөгдлөө. Энэ нь үндэстэн улс хоорондын зэвсэгт зөрчил, тэмцэл, хүн мал амьтны халдварт өвчин, түүний тархалт, улс гүрэн дамжсан алан хядах ажиллагаа, хууль бус цагаачлал, хүний арилжаа, хүрээлэн буй орчны бохирдолт, далайн дээрэм, тагнуул, хар тамхи, зэвсгийн панз наймаа, мөнгө угаах болон компьютерийн гэмт хэрэг гэх мэт урьд өмнө байгаагүй шинэ үйлдлүүдээр илрэх болов.

Дэлхийн аж үйлдвэрийн нийгэм мэдээллийн нийгэм болон хувирч, цаашдаа гуравдахь мянган бол мэдээлэл зүйн эрин байх магадлалтай болсон. Иймд дэлхийн тулгамдсан асуудлуудыг мэдээлэл-судлал, дипломатын аргаар шийдвэрлэж, дэлхийн хамтын нийгэмлэгийг мэдээллийн нөөц, технологигоор хангах явдал чухал болжээ. Иймээс ОУМСП /Олон улсын мэдээлэл судлалын парламент/, ОУМТА /Олон улсын мэдээлэл түгээхүйн академи/ онцгой чухал үүрэгтэй болоод байна.

Нийгмийн мэдээллийн орчныг бүрдүүлсэн ОУМСП бол тэдгээрийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрээс үл хамааран нийгэм төрийн болон олон нийтийн байгууллагуудад мэдээлэл нэвтрэх таатай дэд бүтэц болж байгаа юм.

Орчин үеийн дэлхийчлэгдсэн мэдээлэл судлалын ертөнцийг үзэх үзэл нь дэлхийн хамтын нийгэмлэгийн хөгжлийн бүх талд эерэгээр нөлөөлөх дэлхий нийтийн нийгэм-шинжлэх ухааны байгууллага болох олон улсын мэдээлэл судлалын парламент, /ОУМТА/-ийг байгуулах шалтгаан болсон гэж үздэг. Үүнтэй холбоотой байх зорилгоор МХСҮН /Монголын хил судлалын үндэсний нийгэмлэг/ дээрхи байгууллагын Монголын хил судлалын салбар болон элсээд байна.

Монгол орны нөхцөлд нийгэм ардчилагдаж, хүнлэг энэрэнгүй шинжийг агуулдаг болж, ялангуяа хүчний байгууллагуудад намчирхах, улс төржих байдал үгүй болж иргэд түүний дотор цэргийн албан хаагчдын эрх зүйн хүмүүжлийн үүрэг эрс өсч байна.

Монгол Улсын хил, хязгаар нутгийн нийгэм-улс төрийн үзэгдэл, хүмүүсийн санаа сэтгэлийн байдалд ихээхэн өөрчлөлт гарсан. Нийгмийн сэтгэл зүйн хямрал болсон.

Үүний зэрэгцээ 90-ээд оноос хойш Монголын нийгэм гүнзгий хямралд орж, улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн байдалд сөрөг үзэгдлүүд лавширсны улмаас үндэсний үйлдвэрлэл унаж, ажилгүйдэл, ядуурал газар авч, ялангуяа хүүхэд залуучуудын хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж, тэд ёс суртахууны уналтанд оров. Хөдөөд сургууль хаях, завсардах, “довтолгоо” нэг хэсэг эрчтэй явагдаж бичиг үсэг үл мэдэгчдийн тоо эрс нэмэгдэв. Нийгмийн тогтворгүй байдал, хүмүүсийг бухимдал сэтгэл санааны хямралын уршгаар гэр бүлийн хүчирхийлэл улам бүр нэмэгдэж, ажилгүй тэнэмэл хүүхэд, орон гэргүй амьдрах орчингүй “траншейны” гэгдэх хэсэг бүлэг хот суурин газарт буй болсон. Биеэ үнэлж амьдрах явдлыг охид залуусын зарим хэсэг сонгов. Хулгай дээрэм, тонуул ихсэж, архиан согтуурах явдал газар авч, үүний улмаас гэмт хэрэг, осол, зөрчил эрс нэмэгдэж, хүний амийг бүрэлгэдэг онц ноцтой гэмт хэргийн тоо өсөв. Эдгээр сөрөг үзэгдлүүд хүмүүсийн сэтгэл санаанд нөлөөлж нийгмийн ийм орчинд амьдарч байгаад цэрэгт ирэгсэд гэмт хэрэг сахилгын ноцтой зөрчил гаргаж байна. Эх орны хилийг хамгаалах алба өнөөдөр ядуу зүдүү, ажилгүй, боловсролгүй, хүмүүжилгүй, араасаа хөөцөлдөх хүнгүй “гологдмол” залуучуудын алба болж хувирсан нь цэргийн сахилгад ноцтой сөрөг нөлөө үзүүлэх боллоо.

Энэ нь хил хамгаалалтын ёс суртахуун сэтгэл зүйн хангалт гэсэн цоо шинэ хэлбэрийг буй болгож, үүний бүрэлдэхүүн хэсэг болсон сахилгыг бэхжүүлэх талаар зохиох сурталчилгаа хүмүүжлийн ажлыг удирдах, зохион байгуулах менежментийг өөрчлөхийг шаардаж байна.

Цэргийн сахилгын тухай ойлголтын агуулга, үзэл санааг шинжлэх ухааны онолын үүднээс бүрэн хамжээгээр бүх талаар томъёолох ёстой. Үүний тулд сахилгын нийгмийн мөн чанар, түүхэн онцлог, цогц шинж чанар, нийгмийн үүргийг бүрдүүлэгч хэсгүүдийг нээн илрүүлэх шаардлагатай юм.

Сахилга, тэр дотроо цэргийн сахилга бол нийгмийн үзэгдэл мөн. Тэгвэл мөн чанар нь юунд орших вэ?

Нэгдүгээрт: Цэргийн сахилга нь цэргийн үйл ажиллагаа, түүний субъектүүд, тэдгээрийн харилцааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нийгэм болон хүмүүсийн хоорондын харилцааг эрхийн болон нийгмийн бусад хэм хэмжээгээр баталгаажуулсан цогц мөн.

Хоёрдугаарт: Цэргийн сахилга бол эрхийн болон ёс суртахууны хэм хэмжээг сахиулах нийгмийн хэрэгцээг бие хүн, хамт олны зан байдлыг эерэг субьектив чанар болгон хувиргах үйл явц мөн.

Гуравдугаарт: Цэргийн сахилга нь нийгмийн тодорхой үйл явцын төвлөрүүлсэн шинж чанарыг тусгасан нийгмийн оюун санааны хүчин зүйл мөн.

Дөрөвдүгээрт: Цэргийн сахилга бол улсын хил хамгаалах алба үйл ажиллагаанд үүсэн буй болсон харилцан холбоо бүхий асуудлуудыг агуулсан нийгэм сэтгэл зүйн төлөвшилтийн цогц юм.

Тавдугаарт: Цэргийн сахилга нь улсын хилийг хамгаалах албыг шууд биелүүлж буй хилчид тэдгээрийн хамт олны үйл ажиллагааны нэгдлийг хангахад туслах зорилготой нийгмийн болон эрхийн хэрэгслүүр мөн.

Улсын хил хамгаалах алба нь өөрийн тусгай зориулалттай, төр, нийгэм, ард түмний өмнө хүлээсэн үүрэгтэй, албаа гүйцэтгэх зүй тогтол, өвөрмөц онцлогтой тул хил хамгаалах албаны нөхцөл дэх цэргийн сахилга бас өөртөө өвөрмөц онцлогтой байдаг.

Үүнийг тодруулбал:

1. Цэргийн сахилга нь хил хамгаалах албаны нөхцөлд Монгол Улсын хилийг хамгаалах цэргийн нийгмийн ач холбогдлыг бие бүрэлдэхүүн гүнзгий ойлгосон байдалд үндэслэгдэнэ. Иймээс сахилгын мөн чанарыг гүнзгий ухамсарласан байдлаар илэрнэ. Тэдний нийгэм төрийн өмнө хүлээх хариуцлагаар тодорхойлогдоно.

2. Цэргийн сахилга нь Монгол Улсын үндсэн хууль, тогтоомж, цэргийн дүрэм тушаалуудаар заасан шаардлагуудад суурилж, нийгмийн ёс суртахууны хэмжээ, зарчим, хүн төрөлхтөний ёс зүй, уламжлал, Монголын ард түмний үндэсний ёс заншил үнэт зүйлсэд тулгуурлана.

ХИЛ СУДЛАЛ

3.Цэргийн сахилга бол Монгол Улсын хил хамгаалах байгууллагын амьдрал үйл ажиллагааны бүх талыг хариуцаж байдаг нэгтгэн захирах удирдлагын сахилга мөн.

4.Цэргийн сахилга нь хил хамгаалах албаны нөхцөлд хилчдийн хамт олны эвсэг нөхөрсөг, хамтач үйл ажиллагааны сахилга мөн.

5.Цэргийн сахилга нь бие хүний чанар, шинж байдлын нэгдэл, хилчдийн нийгэм эрх зүйн байдал, үнэт зүйлсийн чиг баримжаа, үзэл санаа, итгэл үнэмшил тэдгээрийн зан суртахуун сэтгэл зүйн чанар, мэдлэг туршлагын бат цул нэгдмэл цогц мөн.

Ёс суртахуун сэтгэл зүйн хангалт нь хил хамгаалах үйл ажиллагааны бүх талын хангалтын үндсэн хэлбэрүүдийн нэг бөгөөд Монгол Улсын хил хамгаалах байгууллагын ёс суртахуун, сэтгэл санааны байдлыг тодорхойлох бие даасан хүчин зүйл юм. Ёс суртахуун сэтгэл зүйн байдлын өндөр түвшин бол бие бүрэлдэхүүнийг ухамсартай сахилгатай болгон хүмүүжүүлэх, сахилга, дэг, зохион байгуулалтыг бэхжүүлэх хууль эрхийн үндсийг бүрдүүлнэ.

Хилчдийн ухамсарт сахилгыг бэхжүүлэхийн тулд хороо, анги, салбар, нэгжүүдэд зохиох ёс суртахуун сэтгэл зүйн хангалтын чиглэл нь:
-төр засаг, ХЦ-ийн командлагчаас нийгмийн дэг журмыг бэхжүүлэх талаар авч явуулж буй арга хэмжээнүүд, энэ талаар гарсан хууль тогтоомжуудыг бие бүрэлдэхүүнд тайлбарлан таниулах;

-гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах, зөрчил гаргагчидтай хийх тэмцлийг хүчтэй болгох, түүнд хамт олны нөлөөг өндөржүүлэх;

- цэргийн нийтлэг дүрэм, тушаал заавруудыг сайн сурталчлах, дотоодын хяналт шалгалт, үзлэгүүдийг хугацаанд нь явуулах, үр дүнг тушаалаар зарлах, зөрчил дутагдал гаргагчидтай хариуцлага тооцох;

-дүрэм зааруудад заагдсан үүрэг, эрхийн биелэлтийг хангах;

-офицер ахлагчдын сэтгэлгээг өөрчлөх, түүнийг латераль болгох ажлын менежментийг сайжруулах, захирагсадтайгаа уйгагүй тулж ажиллах;

-түрүүч нарыг шилж сонгох, зөв сургаж дадлагажуулах, харилцааны зөрчил гаргуулахгүй байх, зэвсэг техник, агт уналгатайгаа зөв харьцах дадлага эзэмшүүлэх;

-штабын албад болон орон нутгийн байгууллагуудад суман салбарыг даалган өгч туслуулах;

-ар гэр ах дүү найз нөхдөд нь захидал бичих;

-хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

-бие бүрэлдэхүүний дунд гэмт хэрэг сахилгын зөрчилгүй хамт олон болох уралдаан зарлаж тогтмол дүгнэж байр эзлүүлж, тэргүүний хамт олны туршлагыг дэлгэрүүлэх;

-чөлөөт цагаар зохиох соёл хүмүүжлийн ажлын агуулга хэлбэрийг боловсронгуй болгох;

-цэргийн албыг дүрмийн дагуу удирдах, сахилга хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой хууль дүрэм зааврууд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудыг судлуулан, зөрчил гаргаж болзошгүй хүнээр баталгаа гаргуулах;

-даарч хөлдөх ахуйн хангалт тасрах, турж эцэх, эрүүл мэнд нь муудахаас хилчдийг урьдчилан сэргийлэх, хилчдийн ар гэрээс захидал ирж байгаа эсэхийг мэдэх, тэдний санал сэтгэлийн байдалд байнга анхаарч, тогтмол уулзаж ярилцах зэрэг ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатай.

**ХЦДС-ийн Байгалийн ухаан,нийгэм
хүмүүнлэгийн тэнхимийн дарга, улс төр
судлалын доктор, профессор, хурандаа
Г.Дагважамц**